



СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Баярын өдрүүдийн үеийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2, 109 дүгээр зүйлийн 109.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.2, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын А/13 тоот тушаал, Эмнэлгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1, 4 дүгээр зүйлийн 4.8.1, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.6.3 -д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 09.00 цаг хүртэлх эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангаж ажиллах хариуцлагатай жижүүр эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд, хариуцлагатай эргүүлийн хуваарь нэрсийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд ажлын цаг ашиглалт болон жижүүр эмчийн журмыг чанд мөрдөж, ажлын хариуцлага, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, хүлээгдэл чирэгдэлгүй үзүүлэхийг жижүүрийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарт, мэдээ тайлангийн үнэн зөв байдлыг хянаж, тулгамдсан асуудлыг хугацаа алдахгүй хариуцлагатай жижүүрт мэдээлж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай эргүүл, жижүүр эмчид үүрэг болгосугай.

3. Тус өдрүүдэд шаардагдах эм, тариа, ороох боох материалыг нөөцөлж, хүрэлцэхүйц хэмжээгээр хангахыг Эмийн сангийн эрхлэгч (Ц.Байгалмаа), ус дулаан, цахилгаан хангамжийн бэлэн аюулгүй байдлыг хангаж, ажиллахыг Эмнэлгийн дэд бүтцийн ахлах инженер (М.Сугар), Цахилгааны инженер (Н.Учрал), бензин шатахуунаар ханган ажиллахыг Санхүү хангамжийн албаны дарга (Ж.Баярмагнай) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Амралтын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар хордлого гарахаас урьдчилан сэргийлж, холбогдох зөвлөмж зааврын дагуу хяналтыг эрчимжүүлж ажиллахыг Халдвараас сэргийлэх хяналт, дархлаажуулалтын албаны дарга (А.Дэлгэрбаяр), Эмнэлгийн автомашины бэлэн байдлыг хангаж ажиллахыг Аж ахуйн албаны менежер (Ж.Төвшинтөгс) нарт тус тус даалгасугай.

5. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын А/13 дугаар тушаалын 6 дугаар хавсралтад заагдсан хуваарийн дагуу мэдээ, тайланг өгч ажиллахыг Статистик эмч (Б.Оюунтуяа) -д үүрэг болгосугай.

6. Эмч эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны анхаарал сулрах, хариуцлага алдах, цагийн хуваарь болон ээлжийг дур мэдэн өөрчлөх, солих, ажлын байрыг орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг асуудал гарахаас сэргийлэх зорилгоор жижүүрийн хугацаандаа эмнэлгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, тэмдэглэл хөтлөн хүлээлцэн ажиллахыг хариуцлагатай эргүүл, хариуцлагатай жижүүр нарт үүрэг болгосугай.

7. Амралтын өдрүүдэд ажилласан ажилтнуудыг биеэр амруулах, амруулах боломжгүй бол илүү цагийг олгохыг Хүний нөөц хөгжлийн албаны дарга (Б.Сүхтулга)-д үүрэг болгосугай.

8. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг танилцуулахыг Дотоод хяналтын менежер (С.Алтанцэцэг)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ц.ОЛОНБАЯР